



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

┌ Сургалт зохион байгуулах тухай ┐

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.7.6, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэр дэх амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан "Амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын үйлчилгээний технологи, стандарт" үзүүлэх сургалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтын төсөв болох 1.420.000 /нэг сая дөрвөн зуун хорин мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад зөвшөөрсүгэй.


3. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/, Үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2015 оны 07 сарын 01-ний өдрийн 1/63 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт



**“АМРАЛТЫН ГАЗАР, ЖУУЛЧНЫ БААЗ, ГЭР БУУДЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ” ҮЗҮҮЛЭХ
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Зорилго: Нийслэлийн аялал жуулчлалын бүс болох Налайх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудын үйлчилгээний чанар, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлагыг дээшлүүлэхэд сургалтын зорилго оршино.

Сургалтын агуулга: Үзүүлэх болон үйлчилгээний ажилтны харилцаа хандлага, онол гэсэн хоёр хэлбэрээр зохион байгуулна. Сургалтын үеэр амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудад мөрдөгдөж байгаа стандарт, жуулчны болон хөдөлмөр, эрүүл ахуйн аюулгүй байдал, үйлчилгээний соёл, харилцаа зэрэг асуудлаар мэдээлэл хийнэ.

Хамрах хүрээ: Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудын удирдах албан тушаалтан болон менежерүүд.

Зохион байгуулагчид: Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Биг скай лоож” амралтын газар

Хугацаа: 2015 оны 07-р сарын 06-ны өдөр 09.00-16.00 цагт

Хаана болох: Налайх дүүргийн “Биг скай лоож” амралтын газарт зохион байгуулагдана.

Хүрэх үр дүн: Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудын үйлчилгээний чанар, стандарт, жуулчны болон хөдөлмөр, эрүүл ахуйн аюулгүй байдлын түвшинд ахиц гарна.

Сургалтын хөтөлбөр:

“Амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын үйлчилгээний технологи,
стандарт” үзүүлэх сургалтын хөтөлбөр

д/д	Сургалтын сэдэв	Хугацаа	Заах багш
1	Нээлт	09.00-09.30	НАЖГ
2	Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын харилцаа, хандлага, ёс зүйн <ul style="list-style-type: none">Хандлага гэж юу вэ, ойлголт, өөрийгөө үнэлэхХандлага юуг орлодог, юуг орлодгүй вэХандлагаа хэрхэн өөрчлөх вэ	09.30-11.00	Т.Насантогтох /Хувь хүний хөгжлийн институт/
3	Аялал жуулчлалын байгууллагуудын тогтвортой хөгжил, бизнесийн төлөв, үйлчилгээний чанарын асуудал, стандарт	11.30-12.00	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн С.Нина
4	Үйлчилгээний салбарын туршлага	12.30-13.00	Нийслэлийн Аялал жуулчлалын газар Маса
Завсарлага		13.00-14.00	
5	Зочинд үйлчлэх үйлчилгээний технологи, өглөөний хоолны иж бүрдэл, төрөл, ширээ засалт, ор засалт практик дадал	14.00-16.00	Монголын зочид буудлуудын холбоо гүйцэтгэх захирал Н.Батцэнгэл

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2015 оны 07 сарын 01-ний өдрийн 463 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт

“АМРАЛТЫН ГАЗАР, ЖУУЛЧНЫ БААЗ, ГЭР БУУДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ” ҮЗҮҮЛЭХ СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Зардал	Тоо ширхэг	Нэгж зардал /төг/	Нийт дүн
1	Багшийн төлбөр /Хувь хүний хөгжлийн институт/	2 цаг	125.000	250,000
2	Багшийн төлбөр /Монголын зочид буудлуудын холбоо/	3 цаг	50,000	150,000
3	Сургалтын цайны зардал	50	20.000	1,020,000
	Нийт зардал			1.420,000